

Монголчуудын арга билгийн сэтгэлгээний үүсэл хөгжлийн тойм

Б.Жадамба^а, Г.Цогзолмаа^{}*
Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль
Боловсролын "суурь судалгааны төв"

Хураангуй

Нүүдэлч өвөг дээдсийнхээ бүтээн өвлүүлсэн уламжлалт соёлын эх сурвалжуудыг шинжин монголчуудын арга билгийн сэтгэлгээ нь тэдний хоёр эшт нитгэл шүтлэг сэтгэхүйн хүрээний “амь” ухагдахуунаас улбаалан эр эмийн сэтгэлгээ болж боловсорч хөгжсөн болохыг нотлохыг зорьсонд уг ажлын онцлог оршино. Магадгүй бид өөрийн гэсэн өв уламжлалтай байсан учраас л Буддын шашин, түүний төв үзэл буюу арга билгийн гүн ухаан ихээхэн өргөжин, монголын уламжлалт соёл лугаа болж түгэн дэлгэрсэн байж болох юм.

Түлхүүр үг

Амь, эр эмийн сэтгэлгээ, Мөнх Тэнгэр үзэл, үйл үрийн гүн ухаан....

Шинжилгээний дизайн: Уг ажлын хүрээнд бид монголын уламжлалт соёлын эх сурвалжуудыг шинжигдэхүүнээр, арга билиг ухагдахууныг шинжих зүйлээр сонгон авлаа. Баримт бичгийн болон танин мэдэхүйн хэл шинжлэлийн арга зүйг хослуулан хэрэглэн гаргасан үр дүнгээ харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх замаар арга билиг ухагдахууны утга, учир, уг чанарыг тодруулсан.

Шинжилгээний баримт, үр дүн:

Баримт 1: “Бөө мөргөлд “арга билэг” гэдэгт хамаатуулж болох хоёр эшт шүтлэг сэтгэхүй юмс үзэгдлийн эши онолыг эсрэг тэсрэгийн холбоонд мөнхүү хүйс ялгалын үүсэлтэй мэдрэмжээс ялгадаг ёстой байжээ. Зөвхөн бөөгийн энэ утгаас нь хэлэхэд эртний монголчуудын гүн ухааны сэтгэлгээний үндсэн сав ай болох юм. Үүнийг үндсэн язгуураар нь буюу монгол ухаанаар “Эр Эмийн сэтгэлгээ” эсвэл «хос сэтгэлгээ» гэж болох бөгөөд эртний нүүдэлчин түмний байгаль ертөнцийг танин мэдэхүй хэмээн оролдсон зурхайн эхлэл ийм аж. Монголын бөө мөргөлийн домог ёсоор бол түүний дээж шүтээн нь тэнгэр мөн бөгөөд тэнгэр бол амьдрал хайрлагч эр эхлэл, газар бол түүнд хэлбэр дүрс хайрлагч эм эхлэл болдог ажээ хэмээн гүн ухааны эрдэмтэд ухаарч байжээ”.

“нитгэл сэтгэхүй нь ямар нэг хэрэг бодсын агуулга, хэлбэрийг үл ялгаж, ерөөс нэг л юмаар ойлгох аж. Тухайлбал, “бөр¹тө чоно”, “гоо марал” эртний монголчуудын баларлаг сэтгэхүйн нитгэл бодсын цогц болж, бодат хаан, хатны дүрээр илэрдэг аж”.

“...бодас оюуны холбоонд авч үздэг

¹Бөр – эртний “нийтийн хэл”-ний язгуур байсан.

✉ tsogzolmaa@msue.edu.mn

логикийн зууч Амь ухагдахуун нь гол байсан гэдгийг хэзээ ч мартаж үл болно. Ахуй ухамсрын ойлголт нэгэнт сансар тэнгэрт мандлаа хэмээн ойлгохоор энэ хоёрын ялгаа нэн тодорхой болж түүний зууч “амь” ухагдахуун болохыг зааж байдаг. Хүн гэдэг нь тэр утгаас амь \ үүнд, үндэс, шим, онгон\, арга \хүйс, эр дүрст язгуур ухагдахуун\ билиг \хүйс, эм дүрст язгуур ухагдахуун\ хэмээх эртний нүүдэлчин түмний гурвалсан сэтгэлгээний шүтэлцээнд тулж байсан”.

“Монголчуудын анх эх байгалийг бэлгэдэж шүтсэн сэтгэхүй нь анх эхэндээ эх байгалийг тус бие нь биш байлаа. Харин ч өөрийн бие нь оногдохуун болж байсныг эрдэмтэд даамай онцгойлж ажсангүй өнгөрүүлсээр хэмээн өмнөх бүлгүүдэд хэлэлцсэн. Юу гэсэн үг бэ? гэвэл эртний хүн өөрийн биеэ байгальтайгаа эн сацуугаар ойлгож, өөрийн биеэ тайлбарлаж үл болох далд хүчин, хүний амин гол, нууц ухагдахуунаа айтвар дээд болгон түүгээр тэнгэр газрыг эр эмээр орлуулах хэмээн оролдож, эх байгалиа түүгээр бэлгэдэн шүтсэн, амь сүнстэй ямар нэгэн шидтэй байдлаар харьцаж байсан аж”.

“Монгол түмний хоёрын дундаас гуравт дэвшдэг сэтгэлгээ монголын уламжлалт язгуур гүн ухаан бололтой..... Амины хүч бол хүн төрөлхтний хамгийн их амьдрахуйн хийдэм \ биегүй, үл үзэгдэх бодот байдал\ хүчин мөн Монгол ардын гүн ухааны анхдагч нь “амьдрахуй ухаан” юм (Тү.Өлзий, 2011, х.6- 303).

Баримт 2: “Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Гоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон

мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж бүхүйд төрсөн Батачихан ажгуу” (Монголын нууц товчоо, 2009, х.5).

Монголчуудын арга билгийн сэтгэлгээ нь шүтэн барилдлагын дундаас шинэ амь мэндэлсэн нь, монгол хүн энэ хорвоодоо гурамсан сэтгэлгээний ойлголт төрөгдөлтэй утга сацуу. Дээрх “Батцагаан” бол хэрэг бодасын ерийн үзэгдэл бус харин хүний шүтэн барилдлагын шинэ амийн тунхаг, үндэс шим, онгоны бүрэлдэл, арга билиг сэтгэлгээ шүтэлцээний үр дагавар, дорно дахины гүн ухааны сэтгэлгээний хоёр эшт онолын ууган голомтын эх дэвсгэр, гэхдээ эр эмийн үнэн сэтгэлгээний үр дүн юм.

Баримт 3: “Арга билиг хоёр нь юмс үзэгдэл, ойлголтыг зөвхөн хоёр ялгасны томьёо биш, харин юмс үзэгдэл ойлголтын хосмог талыг илэрхийлж хос салаа мөчир бүрийг нь хослуулан ургуулж бодсон ухааны үр юм” Тухайлбал “нар” арга болохоор нартай байдаг өдөр, нар ойртон тусдаг зуныг “арга», өдрийн эсрэг шөнө, зуны эсрэг өвлийг “билиг”, халууныг “арга”, хүйтнийг “билиг” гэнэ. ...бодит үзэгдэл юмсын арга билгийн хуваагдал бүрийг дотогш дотогш нь мөн арга билиг гэж үздэг. Өдөр”-ийг “арга” гэвэл үдээс өмнөхийг аргын доторх “арга”, үдээс хойшхыг аргын доторх “билиг” гэж “шөнө” билиг боловч шөнийн дээд хагасыг “билиг”, доод хагасыг “арга” гэх мэтээр тайлбарлажээ (Х.Дарамбазар, 1992, х.2-6).

Баримт 4: Манай монгол хэл, түүнийг тэмдэглэсээр ирсэн бичиг үсэг ч арга билигт шүтэн боловсорсон хэл бичиг юм. Монгол хэлний гол ёс болох - эгшиг гийгүүлэгч зохицох ёс, үе, үг бүтэх ёс, чанга хөндийн зохицол, эр эм үгийн илэрхийлэх утга, бичих горим журам зэрэгт арга билгийн зохист харьцаа, багцран цэгцрэхийн ёсон оршмуй. Тухайлбал, нэрт хэл шинжээч Ш.Лувсанвандан “Агшилга, эгшилгийн гийгүүлэгчийн тухай өгүүлэлдээ”: “Монгол хэлний г-ийн төрлийн үсгийг хуучин монгол бичигт бүгд найман хувилбараар тэмдэглэж байсан нь эр эгшигт үгэнд тохиолдох таван хувилбар, үүнээс эгшгийн өмнө тохиолдох гурван хувилбар, үеийн эцэст тохиолдох хоёр хувилбар, эм эгшигт үгэнд тохиолдох гурван хувилбар, үүнээс эгшгийн өмнө тохиолдох хоёр хувилбар, үеийн эцэст тохиолдох нэг хувилбар болно” хэмээн тэмдэглэсэн байдаг. (Шадавын Лувсанвандангийн эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган IV боть, х.134-135)

Баримт 5: Буддын гүн ухааны Мадхьямака сургаалын Билгийн хувь буюу Хоосон чанарын онолыг үндэслэгч эртний энэтхэгийн их сэтгэгч Нагаржуна энэхүү онолын гол зарчмыг

дараах байдлаар томьёолсон нь эрт эдүгээгийн философичдын дунд алдаршсан юм. Энэ нь: түрдэх үгүй, төрөх үгүй, тасархай үгүй, мөнх үгүй, ирэхүй үгүй, одохуй үгүй, ангит утгат бус, нэгэн утгат бус” хэмээх найман үгүйсгэл болой.... /М.Гантуяа, “Буддын философи судлалын зарим асуудал”, 2004 он, 108-110-р тал/.

Энэхүү найман үгүйсгэл доторх үгүйсгэл тус бүр нь өөртөө түрдэх үгүй нь түрдэх, эс түрдэх; төрөх үгүй нь төрөх, эс төрөх; мөнх үгүй нь мөнх, мөнх бус; тасархай үгүй нь тасрах, эс тасрах; ирэх үгүй нь ирэх, эс ирэх; одох үгүй нь одох, эс одох; ангит утгат бус нь ангит утгат, эс ангит утгат; нэгэн утгат бус нь нэгэн утгат, эс нэгэн утгат гэж. арга, билгийн талыг шүтэлцүүлэн агуулдаг.

Нагаржунайн «Хоосон чанарын далан шүлэгт»-д өгүүлэгдэж байгаа мөнх, мөнх бус; би, би үгүй гэх мэт эсрэг тэсрэг талуудын нэг нь (мөнх, би нь) тухайн тогтолцоог нэгдэлтэй, хэвээр нь байлгах, нөгөө нь (мөнх бус, үгүй) түүнийг задлах, өөрчлөн хувиргах чигийн үүрэгтэй байх агаад эхнийхийг нь билиг, хоёр дахийг нь арга хэмээнэ. Дорно дахины аугаа их гүн ухаантан Нагаржунайн алдарт найман үгүйсгэл доторх үгүйсгэл тус бүр нь өөртөө арга, билгийн талыг шүтэлцүүлэн агуулсан байна хэмээн үзүүштэй. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр, түрдэх үгүй нь түрдэх, эс түрдэх; төрөх үгүй нь төрөх, эс төрөх; мөнх үгүй нь мөнх, мөнх бус; тасархай үгүй нь тасрах, эс тасрах; ирэх үгүй нь ирэх, эс ирэх; одох үгүй нь одох, эс одох гэх мэтээр хоёр талуудад хуваагдан задрах агаад тэдгээрийн нэг нь (эс түрдэх, мөнх, эс төрөх гэх мэт) билиг, нөгөө нь (түрдэх, мөнх бус, төрөх гэх мэт) арга болно гэсэн үг.

Нагаржунайг залгамжлагч дараа дараагийн гүн ухаантнуудын ном бүтээлд ч бас энэ уламжлалыг баримталсаар ирсэн. Тухайлбал, Монголын гүн ухаантан, Монгол даяараа Дандаа хэмээн алдаршсан, гүн ухаантан, нэрт соён гэгээрүүлэгч Дэмчигдорж² өөрийн туурвисан “Эрдэнэт толь хэмээх шашдар оршвой” хэмээх бүтээлдээ “Жич наран саран хийгээд од гариг ба эши эрхтэн хийгээд таван махбод, найман хүлил хийгээд есөн мэнгэ ба өдөр шөнийн ёсон хийгээд чөтгөр сахиулсны хувилах улирах ба уул нуур хийгээд загас мэлхий ба хорхой шоргоолжноос аливаа өвс модонд хүртэл энэ арга билгийн ёсон үгүй нь үгүй. Энэ нь цөм өөрөө болсон, илүү дутуугүй, хослон барилдсан ёсон мөн тул хэн бээр засах эвдэх хийгээд нэмж, бууруулж үл чадна. Арга билгийн ёсон, түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөн буюу. Билгийн ёсон нам буюу.

²1863 онд Өвөрмонголын Зостын чуулганы Хорчин дундад хошуунд төрсөн.

Арга үүрд хөдөлж үл болно. Билиг үүрд нам байж үл болно. Арга билгийг түшиж нам болно. Билиг аргыг дагаж хөдөлнө” \Ч.Дэмчигдорж, 1995, 26 дугаар тал\ хэмээсэн байдаг.

Баримт 6: Эртний Хятадын философийн нэгэн чухал эх сурвалж болсон “И – зин” (“易经”) буюу “Зурхайн сударт” инь (“阴”) - янь (“阳”) философийн талаар тодорхой өгүүлсэн буй. Тэрхүү сударт өгүүлснээр, “Ин” (“阴”), янь (“阳”) хэмээх эсрэг хүчнүүд, тэдгээрийн харилцан үйлчлэл бол ертөнцийн оршин буй бүхний үндэс, мөн бүхний хувьсал өөрчлөлтийн үндсэн шалтгаан болдог” ажээ. “Ин” (“阴”) хэмээх ойлголт нь газар, эх хүн, харанхуй, хүйтэн, зөөлөн, идэвхгүй /тайван байдлыг/ эхлэлийг, өөрөөр хэлбэл, билгийн талыг илэрхийлдэг. Харин “Ян” (“阳”) хэмээх ойлголт нь тэнгэр, эцэг хүн, гэрэл, халуун, хатуу, идэвхтэй /хөдөлгөөнийг/ эхлэлийг, өөрөөр хэлбэл, аргын талыг илэрхийлдэг байна. Энэхүү эсрэг тэсрэг хоёр хүч нь харилцан биенийгээ үгүйсгэхийн хамт бас нөхцөлдүүлж, эцсийн эцэст нэгдэл, зохицолд оршдог бөгөөд тэрхүү нэгдмэл байдлыг “Ци” (“气”) хэмээх ойлголт илэрхийлдэг. Хятад хэлэнд “Ци” (“气”) хэмээх ханз үсгийн утга нь амьдрах хүч бөгөөд философи утга нь анхдагч материаллаг хэсэг гэсэн үг юм. “Ци” (“气”) хэмээх ойлголт агуулгын хувьд өрнийн философийн матери хэмээх ойлголттой их төстэй. Эл натур философийн үзлээр “Ци” (“气”) буюу инь (“阴”), янь (“阳”) харилцан үйлчлэлээс орчлонгийн бүх юмс үзэгдэл төрөн гардаг. /Р.Дарьхүү, Б.Насантогтох “Нийгмийн тухай мэдлэг”, 2004 он, 23-24-р тал/

Баримт 7: Монгол Данжуурт өгүүлснээр гэгээрэлд буюу нигүүлсэнгүй бодь сэтгэлд хүрэх замыг (бясалгалыг) арга, тэрхүү бясалгалын үр дүнд үүссэн хоосон чанарыг билиг хэмээдэг аж. Тэр байтугай “Хутагт дарь эхийн магтаал”-д:

“Төв ухаан тийн ариун цэцгийн дэвсгэр дээр Маргад өнгөт нэгэн нүүр, хоёр мутарт

Идэр маш дэлгэрэн баруун хөлөө жийн зүүнээ хумиад

Арга билиг хослон барилдсан эхэд мөргөмү” (НОМЫН ГЭГЭЭ дээд гурван засал 1, 2012, 51-р тал) хэмээн шүлэглэсэн байх аж.

Баримт 8: Тэгэхээр эртний Монгол ухаант өвөг дээдсийн маань айлдсан Мөнх Тэнгэрийн философид багтах бас нэгэн гайхамшигт дээд үнэний номлол бол арга билгийн тухай үнэний философи гэж шуудхан хэлж болно байх. Үнэндээ арга билгийг төгс ухаарч байсны хүчинд л дэлхийг эрхшээлдээ оруулах арга ухааныг олж авсан гэдгээ их эзэн Чингис хааны айлдсан “Арга билгийг мэдвээс аливаа хүчтэнийг эрхэндээ оруулна” хэмээх айлдвар нь бэлхнээ нотолдог билээ. Тэгвэл арга билиг гэдэг бол нэгийг нь нөгөөгөөс нь салгаж ухаарч үл болох өөрөөр хэлбэл нэг нь байвал нөгөө нь мөн заавал байх ёстой, нэг нь мөхвөл нөгөө нь мөн дагаад мөхдөг жамтай тийм гайхамшигт харилцан шүтэлцээт ойлголтууд байдгийг эртний Монголчууд сайн мэднэ.... Ер нь хөгжил бол эсрэг тэсрэгийн нэгдэл гэдэг шиг арга билиг бол харин ч хөгжлөөр үл барам орчлон ертөнцийн оршин тогтнох тулгуур хоёр багана нь буюу нууцыг тайлах түлхүүр нь гэвэл бараг хилсдэхгүй болов уу. Үнэндээ өнөөдөр арга билгийн энэ гайхамшигт дээд үнэний нууцыг олж харж ухаарч чадаагүйгээс болж л хүн төрөлхтний хөгжил эцэстээ дэлхий ертөнцийг мөхлийн ирмэг дээр авчирчихлаа гэдгийг бид одоо олон жишээ баримтаар нотолж болно. Тухайлбал өдгөө билгийн иргэншил гэгдэх нүүдэлчний иргэншил бараг устаж, харин аргын иргэншил гэгдэх суурин иргэншил дангаар ноёрхох болсноос эх дэлхий маань мөн л мөхлийн ирмэг дээр тулж ирчхээд байна шүү дээ. Гэхдээ энэ үнэнийг бид гагцхүү эх дэлхийгээ амьд тогтолцоо буюу ухаант амьтан гэдгээр олж харж үнэнийг ухаарч чадсан тохиолдолд л мэдэх болно (Арилдзэмбэ, 2017, х.34-36).

Энэ бүгдийг нэгтгэн, монголчуудын арга билгийн ухааныг дараах байдлаар цэгцэрч хөгжсөн гэж таамаглаж болохоор байна:

Үе шат	Арга билиг	Арга	Билиг
I	Хүйс /Үндэс, Шим, Онгон/	Эр хүйс /эр дүрст язгуур ухагдахуун/	Эм хүйс /эм дүрст язгуур ухагдахуун/
II	Этүгэн бөө	Бөө	Этүгэн
III	Тэнгэр газар	Эцэг тэнгэр	Этүгэн эх
IV	Батцагаан /Хүү/	Бөртө чоно /Эцэг/	Гоо марал /Эх/
V	Цаг Тэнгэр /Мөнх Тэнгэр/	Цаг /Мөнх/	Тэнгэр
VI	Үйл Үр /Үйл Нэг/	Үйл	Үр /Нэг/
VII	Гэгээрэл /Нигүүлсэнгүй бодь сэтгэл/	Бясалгал /гэгээрэлд хүрэх зам/	Хоосон чанар /бясалгалын үр дүн/

Дүгнэлт

Арга билгийн талаарх эх үүсвэрүүдийг харьцуулан, задлан шинжилж нэгтгэснийхээ үндсэн дээр бид дараах дүгнэлтийг хийж байна:

- Монголчуудын арга билгийн сэтгэлгээ нь бөөгийн ёсны хоёр эшт шүтлэг сэтгэхүйгээс эхлэн амь ухаан,эр эмийн сэтгэлгээ, Мөнх Тэнгэр үзэл, “Үйл Үр” -ийн прагматик гүн ухаан болж хөгжсөөр иржээ.
- Монголчуудын арга билиг нь Хятадын ин янь (“阴阳”), Буддын гүн ухааны арга билгээс үүсэл гарлын хувьд ялгаатай байна,
- Хятадын ин янь (“阴阳”) нь монголчуудын арга билгийн хөгжлийн гуравдугаар үеийн орчим үүссэн байж болохоор байна,
- Монголчуудын арга билгийн уг чанар нь хорвоогийн буюу хоосны шалтгаан болох амь байна.

Ном зүй

- Арилдзэмбэ, Ж. (2017). Хүн төрөлхтнийг аварч хөтлөх мөнх тэнгэрийн философи, Улаанбаатар., 34-36 дугаар тал.
- Дарамбазар, Х. (2017). Ариун ёс, Улаанбаатар., 2- 6 дугаар тал.
- Дарьхүү, Р., Насантогтох, Б. (2004). Нийгмийн тухай мэдлэг, Улаанбаатар., 23-24 дүгээр тал.
- Дэмчигдорж, Ч. (1995). Эрдэнэт толь хэмээх шастир оршвой, Улаанбаатар., 26 дугаар тал.
- Гантулга, М. (2004), Буддын философи судлалын зарим асуудал, Улаанбаатар., 108-110 дугаар тал.
- Өлзий, Тү. (2011). Эртний монголчуудын бөө мөргөлийн соёл сэтгэхүй, Улаанбаатар., 251-254 дүгээр тал.
- Шадавын Лувсанвандан. (2019). Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган IV боть, Монгол хэлний авиа, үсэг бичгийн судлал - Агшилга, эгшилгийн гийгүүлэгчийн тухай, Улаанбаатар. 134-135 дүгээр тал.

Development overview of Mongolians wisdom mindset origins

Jadamba.B, Tsogzolmaa.G, MNUE

Abstract

This following research work is dedicated to proving towards Mongolian's thinking **of Genius** was as a developmental source as well as a two root scale by analyzing the original sources, which are created by the nomadic ancestors of traditional cultural heritage. In all probability Mongols have had their own inherent heritage that is why Buddhism its central philosophy and philosophy of **Genius** have expanded greatly as a traditional Mongolian culture.

Keywords

Gender thinking, theory of the Eternal SkyМөнх, philosophy of karma...